



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/375

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Найрамдлын-2-202 тоот)-д байршилтай Дундговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар (РД:9033874)-ийн зуслангийн зориулалттай 21000 м.кв (2,1га) газраас хавсралтад заасан төрийн байгууллагуудад тус тус зориулалтаар нь шилжүүлж 27 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Хавсралтад заасан байгууллагуудтай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, бөгөөд Мандалговь хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/243 дугаар захирамжийн Дундговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-т холбогдох хэсэг мөн газар эзэмших 000005687 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА:  Ц.МӨНХБАТ

4822111228